



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/456

Есөнбулаг

“Бурхан буудай” уулын тэнгэрийг
тайх төрийн ёслолыг зохион байгуулах
комисс томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зохицуулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 183, 2010 оны 85 дугаар зарлиг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 110 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн тахилгат “Бурхан буудай” уулын тэнгэрийг тайх төрийн ёслолыг зохион байгуулах комиссыг нэгдүгээр хавсралтаар, ёслолыг зохион байгуулах төв комисс, салбар комиссуудын чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төрийн тахилгат “Бурхан буудай” уулын тэнгэрийг тайх төрийн ёслолын бэлтгэл ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг нарийвчлан боловсруулж 2024 оны 07 дугаар сарын 01-ний дотор, төлөвлөн зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй тайлан бичиж 2024 оны 08 дугаар сарын 01-ний дотор танилцуулан, архивын баримтыг бүрдүүлж, аймгийн комиссын нарийн бичгийн даргад хүлээлгэн өгөхийг салбар комиссын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газартай ажлын уялдаа холбоог хангаж ажиллахыг зохион байгуулах комисс (Г.Чинбат)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР





התאחדות חקלאים

אגודת חקלאים

אגודת חקלאים

1. האגודה תישא באחריות כלכלית על כל פרויקטים שהיא מבצעת...

2. האגודה תישא באחריות כלכלית על כל פרויקטים שהיא מבצעת...

3. האגודה תישא באחריות כלכלית על כל פרויקטים שהיא מבצעת...

4. האגודה תישא באחריות כלכלית על כל פרויקטים שהיא מבצעת...

5. האגודה תישא באחריות כלכלית על כל פרויקטים שהיא מבצעת...

6. האגודה תישא באחריות כלכלית על כל פרויקטים שהיא מבצעת...

7. האגודה תישא באחריות כלכלית על כל פרויקטים שהיא מבצעת...

8. האגודה תישא באחריות כלכלית על כל פרויקטים שהיא מבצעת...

אגודת חקלאים
«התאחדות חקלאים»

10000 00 00

Handwritten signature

תאריך: 01/08/00



התאחדות חקלאים
אגודת חקלאים

Аймгийн Засаг даргын
20.26 оны 06 дугаар сарын 26-ны
өдрийн 436 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

Нэг. ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨВ КОМИСС

Дарга:
Дэд дарга:

Гишүүд:

Аймгийн Засаг даргын орлогч
Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Нарийн
бичгийн дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Аймгийн Засаг даргын Зөвлөх
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа,
удирдлагын хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого,
төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-
шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын
дарга
Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн захирагч, Алтай
цэргийн хүрээний дарга
Тагнуулын ерөнхий газрын Говь-Алтай аймаг дахь
хэлтсийн дарга
Аймгийн Цагдаагийн газрын дарга
Аймгийн Онцгой байдлын газрын дарга
Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
Аймгийн Соёл, урлагийн газрын дарга
Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга
Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
дарга
Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын
газрын дарга
Аймгийн "Алтай" усан спорт чийрэгжүүлэлтийн төвийн
захирал
Аймгийн "Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төв"
УТҮГ-ын захирал
Аймгийн "Дашпэлжээлин" хийдийн Хамба лам
Аймгийн "Нийтлэг үйлчилгээ" УТҮГ-ын газрын дарга
Бигэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
Бигэр сумын Засаг дарга
Цогт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
Цогт сумын Засаг дарга
Халиун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

Халиун сумын Засаг дарга
Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нар
Сумын Засаг дарга нар
Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсрол, соёл урлаг, шинжлэх ухааны бодлого хариуцсан мэргэжилтэн
Аймгийн Соёл, урлагийн газрын Соёл, урлагийн хэлтсийн дарга

Хоёр. Төрийн ёслол хүндэтгэлийн салбар комисс:

Дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Дэд дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
Гишүүд: Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
Тагнуулын ерөнхий газрын Говь-Алтай аймаг дахь хэлтсийн дарга
Аймгийн Дашпэлжээлин хийдийн Хамба лам
Аймгийн Жангар номын сангийн дарга
Бигэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
Цогт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
Халиун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дайчилгааны офицер

Гурав. Хөрөнгө, санхүү, төсвийн салбар комисс:

Дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга:
Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодогч
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Дөрөв. Кэмпийн зохион байгуулалт, тохижилтын салбар комисс:

Дарга: Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн захирагч, Алтайн цэргийн хүрээний дарга /зөвшилцсөнөөр/
Дэд дарга: Аймгийн Онцгой байдлын газрын дарга
Гишүүд: Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Аймгийн Алтай Улиастай Эрчим хүчний систем ТӨХК-н захирал

Аймгийн Цахилгаан холбооны газрын захирал
Аймгийн Ундарга-Алтай ААТҮГ-ын газрын дарга
Аймгийн Нийтлэг үйлчилгээ УТҮГ-ын
газрын дарга
Алтай хотын Тохижилт үйлчилгээний газрын дарга
Бигэр сумын Засаг дарга
Цогт сумын Засаг дарга
Халиун сумын Засаг дарга
"Хан-Алтай ресурс" ХХК
Нарийн бичгийн дарга: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч

Тав. Аж ахуй, үйлчилгээний салбар комисс:

Дарга: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга
Дэд дарга: Аймгийн Засаг даргын Зөвлөх
Гишүүд: Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
Аймгийн Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгаалалын газрын
дарга
Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
Аймгийн Статистикийн хэлтсийн дарга
Аймгийн Мал, эмнэлэгийн газрын дарга
Есөнбулаг сумын Засаг дарга
Бигэр сумын Засаг дарга
Цогт сумын Засаг дарга
Халиун сумын Засаг дарга
Аймгийн төвийн Ерөнхий боловсролын сургуулийн
захирал нар
Аймгийн төвийн Цэцэрлэгийн эрхлэгч нар
Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого,
төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Геологи, уул
уурхай хариуцсан улсын байцаагч

Зургаа. Соёл, урлагийн салбар комисс:

Дарга: Аймгийн Соёл, урлагийн газрын дарга
Дэд дарга: Аймгийн Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын дарга
Зөвлөх: Э.Баатаржав -Төрийн батламжит туульч
Гишүүд: Аймгийн "Жангар" музейн захирал
Аймгийн "Жангар" номын сангийн дарга
Аймгийн "Дашпэлжээлин" хийдийн хамба лам
Нарийн бичгийн дарга: Аймгийн Соёл, урлагийн газрын Захиргаа,
удирдлагын хэлтсийн дарга

Долоо. Бэсрэг наадам зохион байгуулах салбар комисс:

Дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-
шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн
бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн
дарга
Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Аймгийн газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын дарга
Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга
Аймгийн Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгаалалын
газрын дарга
Аймгийн Ардын дуу бүжгийн Алтай чуулгын
ерөнхий найруулагч
Сумдын Соёлын төвийн дарга нар
Нарийн бичгийн дарга: Аймгийн "Жангар" музейн захирал

Найм. Эх бэлтгэл, брэндбүүк хариуцсан салбар комисс

Дарга: Аймгийн "Инноваци судалгаа, бизнес хөгжлийн
төв" УТҮГ-ын захирал
Гишүүд: "Аймгийн Инноваци судалгаа, бизнес хөгжлийн
төв" УТҮГ-ын мэргэжилтнүүд
Нарийн бичгийн дарга: "Инноваци, судалгаа бизнес хөгжлийн төв"
УТҮГ-ын ахлах мэргэжилтэн

Ес. Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны салбар комисс:

Дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн дарга
Дэд дарга: Аймгийн архивын тасгийн дарга
Гишүүд: Алтай телевиз
Алтай мэдээ агентлаг
Аймаг дахь "Монцамэ" агентлаг
Нарийн бичгийн дарга: Засаг даргын хэвлэл мэдээллийн ажилтан

Арав. Нийтийн хэв журам, аюулгүй байдлын салбар комисс:

Дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх
зүйн хэлтсийн дарга
Дэд дарга: Аймгийн Цагдаагийн газрын дарга
Гишүүд: Аймгийн Онцгой байдлын газрын дарга
Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
Тагнуулын ерөнхий газрын Говь-Алтай
аймаг дахь хэлтсийн дарга
Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга
Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн
тасгийн дарга
Нарийн бичгийн дарга: Цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах, олон
нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн дарга

Аймгийн Засаг даргын
20.24. оны 06 дугаар сарын 26 -ны
өдрийн 437 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт

КОМИССЫН ЧИГ ҮҮРГҮҮД

Нэг. Аймгийн төв комиссын чиг үүрэг :

Төрийн тахилгат "Бурхан буудай" уулын тэнгэрийг тайх төрийн ёслолын бэлтгэл ажлын нэгдсэн төлөвлөгөө боловсруулан, батлуулж, нэгдсэн удирдлагаар хангах, төрийн ёслолын дэгийг чанд сахиж, ёслолын үйл ажиллагааг өндөр хэмжээнд зохион байгуулах;

Хоёр. Төрийн ёслол хүндэтгэлийн салбар комиссын чиг үүрэг:

Төрийн ёслолд оролцох төр болон шашны өндөр албан тушаалтай хүмүүсийн нэрсийг гаргаж урилга хүргүүлэх, угтаж авах, кэмгийн гэрийг тохижуулж, зочдыг хуваарилан байрлуулах, үйлчилгээний багийг бүрдүүлж, удирдлагаар хангах, тахилга болон долоон бурханы овоог ёслолд бэлэн болгох, тайх ёслол үйлдэх байрлалын зураглал, маршрут гаргах, тахилгын үеэр залах "Ганжуур", "Эх хөлгөн судар", "Найман тахил", "Бурхан буудай уулын сан" зэрэг номууд, төрийн 7 эрдэнэ болон тахилгат хэрэглэгдэх төр, шашны бэлгэдлүүд, овооны хүндэтгэлийн ширээ сандал, идээ бусад холбогдох зүйлийг ёслолд бэлтгэх;

Гурав: Хөрөнгө, санхүү, төсвийн салбар комиссын чиг үүрэг:

Төрийн тахилгат "Бурхан буудай" уулын тэнгэрийг тайх төрийн ёслолыг зохион байгуулахад зарцуулагдах хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх, хандив тусламж авах ажлыг зохион байгуулах, орлого зарлагын бүртгэл тооцоог хөтөлж, гүйцэтгэлд хяналт тавих, санхүүгийн баримт материалыг бүрдүүлж, аудит хийлгэн архивт хүлээлгэн өгөх;

Дөрөв: Кэмгийн зохион байгуулалт, тохижилтын комисс:

Кэмгийн ерөнхий зураглал гаргаж, батлагдсан зургийн дагуу зочдыг хүлээх авах гэр, хүндэтгэлийн өргөө, гал тогоо, урлагийн тайз, ариун цэвэр болон хог хаягдлын байгууламжийг барьж байгуулах, тог, цахилгаан, интернет, сүлжээ ундны усаар хангах, гадна орчны тохижилт, чимэглэлийг хийж гүйцэтгэх;

Тав: Аж ахуй, үйлчилгээний салбар комисс:

Төрийн ёслолд оролцож байгаа төрийн болон шашны төлөөлөгчдийг кэмпэд байрлуулах, эрүүл аюулгүй хоол хүнсээр хангах болон үйлчилгээний ажилчдыг байр, хоол хүнс, удирдлагаар хангаж, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийг зохион байгуулалтад оруулж, хяналт тавих;

Зургаа: Соёл, урлагийн салбар комисс:

Төрийн тахилгат "Бурхан буудай" уулын тэнгэрийг тайх төрийн ёслолын үеэр Алтайн магтаал, "Бурхан буудай" уулын магтаал, тууль хайлах, долоон бурхан одны тахилга, хүндэтгэлийн тоглолт зохион байгуулах;

Долоо: Бэсрэг наадам зохион байгуулах салбар комисс:

Төрийн тахилгат "Бурхан буудай" уулын тэнгэрийг тайх төрийн ёслолын хүрээнд "Эрийн гурван наадам"-ыг зохион байгуулах;

Найм: Эх бэлтгэл, брэндбүүк хариуцсан салбар комисс:

Төрийн тахилгат "Бурхан буудай" уулын тэнгэрийг тайх төрийн ёслолтой холбоотой брэндбүүк, бүх төрлийн эх бэлтгэл, контентийг боловсруулан бэлтгэх

Ес. Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны салбар комисс:

Төрийн ёслолын үйл ажиллагааг сурталчлах, үндэсний болон олон нийтийн телевизүүд, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаар хуваарийн дагуу шууд дамжуулан, хүргэх, тахилгын ёслолын баримт бичиг, гэрэл зураг, баримтат кино контент зэргийг баримтжуулан архивын сан хөмрөгт хадгалуулах;

Арав. Нийтийн хэв журам, аюулгүй байдлын салбар комисс:

Төрийн ёслол зохион байгуулахад хамаарах газар нутагт хамгаалалтын бүс тогтоох, замын маршрут, тэмдэг, тэмдэглэгээг байршуулах, зочид, төлөөлөгчид, ард иргэдийн зорчих болон үйл ажиллагаанд оролцох үеийн аюулгүй байдлыг бүрэн хангах, хамгаалалт зохицуулалтын хүн хүчнийг ажиллуулах;